

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2022-07-07/**

Ажлын хэсгийн 59 дугаар хуралдаан 2022 оны 07 дүгээр сарын 07-ны өдрийн 10.00 цагт цахим хэлбэрээр зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалыг орлож УУХҮЯ-ны Статистик, судалгааны хэлтсийн дарга Б.Дэлгэржаргал, БОАЖЯ-ны мэргэжилтэн Д.Дамбасүрэн, Татварын ерөнхий газрын байцаагч Ч.Батцэнгэл, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтүяа, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Т.Мөнхбат, Бороо гоулд ХХК-ийн татварын нягтлан бодогч Т.Мөнхзул, Рио Тинто Монгол ХХК-ны менежер Б.Даваасүрэн, Бадрах энержи ХХК-ны ЭМХАБОТХ-ийн асуудал хариуцсан захирал Ц.Энхжаргал, Петрочайна Дачин Тамсаг ХХК-ын ахлах нягтлан бодогч Ц.Болормаа, ТАН эвслийн зохицуулагч Ц.Туяацэцэг, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Хүний эрх хөгжил төв ТББ-ын тэргүүн Г.Уранцож, Эрхүүгийн Улс ардын аж ахуйн дээд сургуулийг төгсөгчдийн холбооны тэргүүн Л.Бямбажавыг орлож Д.Цэрэнжав, Монголын байгаль эхийн аврал сангийн тэргүүн Н.Наранцэцэг, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, Транспоренси Интернейшнл Монгол байгууллагын менежер Н.Мөнхжаргал, МБОИЗ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Бээжин болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 19 гишүүн оролцож, ирц 57,6 хувьтай байв.

Мөн хуралдаанд Энержи ресурс ХХК-ны албаны дарга З.Сугармаа, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Эс Ай Си Ай ХХК-ийн дэд захирал Г.Эрдэнэ, ТАН эвслийн гишүүн Б.Цэрэнханд, Мэдээлэл технологийн зөвлөх В.Нармандах, харилцааны мэргэжилтэн З.Цэлмэг, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны Статистик, судалгааны хэлтсийн дарга Б.Дэлгэржаргал удирдав.

Б.Дэлгэржаргал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр ОҮИТБС-ын ажлын хэсгийн 59 дүгээр хуралдаанаар Монголын ОҮИТБС-ын 2022 оны Баталгаажуулалтын зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, Баталгаажуулалтын төлөвлөгөөний төсөлд ТАН эвслээс өгөх санал, компаниудаас өгөх санал болон Монголын ОҮИТБС-ын 2021 оны нэгтгэл тайлангийн материаллаг байдал цар хүрээг тодорхойлох, ОҮИТБС-ын суурь мэдээллүүд, ажлын даалгаварт шаардсан мэдээллийг ил тод болгох асуудлаар эхлэлийн тайлангийн танилцуулгыг сонсож, хэлэлцэнэ. Хурлын материалыг тараасан байгаа, урьдчилан судалж, товч тодорхой асуулт тавих байх гэж найдаж байна. Баталгаажуулалтын тайлангийн зөвлөмжийг биелүүлэхэд бидний зорилго чиглэж байгåа мөн 2021 оны нэгтгэл тайлан гаргахад талууд идэвхтэй оролцно гэдэгт найдаж байна. Ингээд хөтөлбөрийн дагуу Баталгаажуулалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна.

Танилцуулга нэг: Монголын ОҮИТБС-ын Баталгаажуулалтын зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний төслийн танилцуулга.

Ш.Цолмон: Сайн байцгаана уу, 2022 онд баталгаажуулалт хийгдэж, зөвлөмжийг ирүүлсэн байгаа, үүнийг аль болох товчон танилцуулья.

Зөвлөмжийн дагуу хийх арга хэмжээг ажлын төлөвлөгөөнд тусган ажиллах шаардлагатай байгаа. 2022 оны баталгаажуулалтын тайлангаар 34 зөвлөмж гарсан байна. Зөвлөмжийн нэгдүгээрт, ОҮИТБС-ын 2023 оны ажлын төлөвлөгөөг олон улсын стандартын дагуу боловсруулж, биелэлтэд хяналт тавих ажлыг ажлын алба хариуцна; хоёрдугаарт, ИНБ-ын гишүүдийг 2022-2023 онд холбогдох сургалтанд хамруулах; гуравдугаарт, ОҮИТБС-аас гарч байгаа мэдээллийг 2023 онд нээлттэй өгегдөл болгох; дөрөвдүгээрт, жил бүрийн тайлангийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх дэд ажлын хэсэг байгуулж ажиллах; тавдугаарт, шаардлага 7,4-ийн зөвлөмжийн дагуу ажлын дэд хэсгийн ажлын удирдамжаар өөрийн үнэлгээ гаргуулж, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулдаг байх зэрэг арга хэмжээг Ажлын алба хариуцан ажиллахаар төлөвлөсөн байна. Та бүхэн асуух асуулт байвал хариулахад бэлэн байна, баярлалаа. (Төлөвлөгөөний төслийг хавсаргав)

Танилцуулга хоёр: Монголын ОҮИТБС-ын Баталгаажуулалтын зөвлөмжийн талаар ТАН эвслээс гаргах саналын танилцуулга.

Н.Баярсайхан: Миний бие ТАН эвслийн удирдах зөвлөлөөс чөлөөлөгдсөн байгаа. ИНБ-үүд Төлсөнөө нийтлээ эвслийн хүрээнд гэрээний хэрэгжилтийн талаар санхүүгийн дэмжлэгтэйгээр нилээд ажлуудыг хийж байгаа. Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төслийг урагшуулах нөлөөллийн ажлыг Хил хязгааргүй алхам ТББ ахлан ажиллаж байна. ОҮИТБС-ын баталгаажуулалтын үнэлгээний тайлангийн төсөлд ТАН эвслийн гишүүд тодорхой санал боловсруулсан, үүнийг би өнөөдөр ТАН эвслийг төлөөлж танилцуулах гэж байна. Мөн Баталгаажуулалтын үнэлгээний тайланд эвслийн байр суурийг нэгтгэхдээ удаа дараагийн хэлэлцүүлэг, уулзалт хийж ИНБ-уудын саналыг нэгтгэх ажлыг хийсэн. 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр ТАН эвсэл болон МБОИЗ-ын гишүүдэд хэлэлцүүлгийн зарыг түгзэж, саналыг төслийг урьдчилан мэйлаар хүргүүлсэн. Харин МБОИЗ-ын төлөөлөл хараахан ирээгүй, гэхдээ бид цаг хугацаа зарцуулж, тайлантай танилцсан. Хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгээд ТАН эвслийн гишүүдэд 2 удаа боловсруулсан бичиг баримтыг явуулсан. Тийм учраас энэ санал нь гурван удаагийн хэлэлцүүлгийн үр дүнд ТАН эвслээс гарсан санал гэж үзэх юм. ТАН эвсэл баталгаажуулалтын үнэлгээ хийх судалгаа, ярилцлага зэрэг бүх үйл явцад цаг гаргаж, оролцсон мөн тайлангийн төслийг уншиж, зөвлөлдсөн, энэ хүрээндээ саналыг боловсруулсан.

Баталгаажуулалтын тайлангийн төсөлд дараах саналуудыг тусгасан байна. Үүнд, “Монгол улс нь ОҮИТБС-ын 9 шаардлагыг бүрэн, 18 шаардлагын ихэнхийг хангаж, харин 3 шаардлагыг хэсэгчлэн хангаснаар ОҮИТБС-ын 2019 оны Стандартын хэрэгжилтэд нийт нэлээд доогуур оноо авсан.” гэжээ. Сүүлийн жилүүдэд санаачилгын хэрэгжилт ийнхүү суларсан нь ОҮИТБС-ын хэрэгжилтийг хангахад төр засгийн хэмжээнд өндөр дээд түвшний манлайлал, дэмжлэг дутағдсантай холбоотой гэж иргэний нийгмийн байгууллагууд үзэж байна. Тодруулбал, ОҮТИБС-ын Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлдэг байсныг өөрчилж, УУХҮ-ийн сайд тэргүүлэх болсон бөгөөд Ажлын албыг УУХҮЯ-нд харьяалуулахаар болгосон.

Харин УУХҮЯ нь ОҮИТБС-ыг олон улсын төсөл гэдэг өнцгөөр харж, олон улсын өмнө хүлээсэн заавал биелүүлэх амлалт, салбарын засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн мэдэх эрхийг хангах

арга хэрэгсэл гэж ойлгохгүй, ач холбогдол өгөхгүй байна. Ийм ч учраас 2020 онд боловсруулж, УИХ-ын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барихгүй өнөөг хүрлээ. Тэрчлэн ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд БОАЖЯ, ХЗДХЯ, СЯ, АТГ гэх зэрэг бусад салбарын төрийн захирагааны төв болон бусад байгууллагуудын идэвхтэй оролцоог шаарддаг, ОҮИТБС-ын хэрэгжилтийг эрх хэмжээний хувьд ижил түвшний аль нэг яаманд дагнан хариуцуулснаар дээрх байгууллагуудыг татан оролцуулахад бэрхшээл учруулж, ил тод тайлagnalыг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хэвшүүлэн хэрэгжүүлэхэд дээрх бүх байгууллагуудыг нэгтгэн удирдах, уялдаа холбоог хангах шаардлага үүснэ. Иймд ОҮИТБС-ыг Засгийн газрын түвшинд харьяалуулах нь зүйтэй;

ОҮИТБС-ын баталгаажуулалтын тайлангийн төслийн дүгнэлт, зөвлөмжид хэд хэдэн удаа Эрдэс баялгийн ил тод байдлын бие даасан хууль батлуулах тухай онцлон дурдсаныг талууд онцгойлон анхаарч цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ТӨК-ийн чиглэлээр хийгдэж байгаа эрх зүйн шинэчлэл, засаглал, үр нөлөө, тэр дундаа ил тод тайлagnalын асуудлыг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэж, байр суурь илэрхийлэх хэрэгтэй байна.

ОҮИТБС-ын 15 жилийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээ хийж, цаашид жил тутам үнэлдэг болох, үүнд тайлангийн иж бүрэн байдал, цар хүрээг өргөжүүлэх, талуудын оролцоог нэмэгдүүлэх гэх мэт асуудлаарх талуудын санал, байр суурийг тусгах шаардлагатай байна.

Иргэний нийгмийн оролцоог өргөн хүрээнд харж, ОҮИТБС-аас гадуурх бодлогын хэлэлцүүлэгт оролцуулах. УУХҮЯ хууль тогтоомжийн төсөл боловсруулахад олон нийт, сонирхогч талууд, ялангуяа иргэний нийгмийн оролцоог хангах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ хүндэтгэн хэрэгжүүлэх мөн Үндэсний зөвлөл, ОТАХ, орон нутгийн түвшин дэх дэд зөвлөлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог бодитой болгож, МУУҮА нь компаниудын төлөөлөл тул компаниудад хүрч ажиллах, Үндэсний зөвлөл, ОТАХ-т орж байгаа томоохон компаниуд нь жижиг, дунд компаниудад жишиг болгох, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд тодорхой уриалга, санаачилга гаргаж ажиллах хэрэгтэй байна.

Баталгаажуулалтын оноонд өгөх саналыг хүснэгтээр бэлтгэн, боловсруулсан. Танилцуулгыг та бүхэн харсан байх, санал асуулт байвал бид хариулья, баярлалаа.

Б.Дэлгэржаргал: За баярлалаа. ОҮИТБС-ын баталгаажуулалтын үнэлгээний тайланд өгөх компаниудын саналыг МУУҮА-ын гүйцэтгэх захирал Б.Эрдэнэтуюяа танилцуулна.

Б.Эрдэнэтуюяа: Сайн байцаана уу, бид өнгөрсөн долоо хоногт ОҮИТБС-ын ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд орох компанийдын бүрэлдхүүнийг шинэчлэх болон цаашид хэрхэн хамтран ажиллах, компаниудаа идэвхжүүлэх талаар Ажлын албаны зохицуулагч Цолмон гуайтай ярилцсан байгаа. Гишүүн компаниуд тайлан мэдээ гаргах тал дээр харьцангуй идэвхтэй оролцдог. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх компаниудын тоог нэмэгдүүлэх, гишүүдийн тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагаа сайжруулах тал дээр төлөвлөгөө гарган ажиллаж байгаа. Баталгаажуулалтын зөвлөмжид шаардлага 1-ийн 2-т манайтай холбогдолтой зөвлөмж байгаа. Үүн дээр тодорхой ажлуудыг хамраад хийх бодолтой байна. ТАН

эвслийн саналыг сонслоо, хуулийн асуудлыг ярьж байна. Бидний зүгээс хууль батлуулахаас илүүтэй хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй гэж харж байгаа. Бидэнд хангалттай олон хуулиуд байгаа.

Одоо гадаадын хөрөнгө оруулалт буурсан, Оюутолгойн гүнийн уурхай эхэлвэл хөрөнгө оруулалт зогсохоор цаг үед байна. Иймээс гаднын хөрөнгө оруулалтын татахын тулд хууль эрхзүйн орчныг тогтвортой байлгах, татварын орчныг таатай байлгахад оролцогч талууд анхаарлаа хандуулах цаг нь болсон болов уу. Гэрээг ил тод байлгах, нийгмийн хариуцлагын гэрээг нээлттэй байх гэдэг нь өөр хуулиуд дээр байж л байгаа. Иймээс түүний хэрэгжилтийг хангахад бид хамтраад юу хийж болох вэ гэдгийг ярих хэрэгтэй гэж бодож байна.

Эдийн засгийн ийм хүндрэлтэй нөхцөлд бэрхшээлийг даван туулахад нилээн хүндрэлийг туулахыг ойлгож байна. Иймд ИНБ, алжлын албатай хамтраад юу хийж болох талаар тодорхой төлөвлөгөө гаргаад идэвх санаачилгатай ажиллана. ОҮИТБС-ын цахим хуудас руу орж үзэхэд тайлан мэдээ маш хоцрогдолтой, 2 жилээр хоцорч байгаа нь харагдсан. Үүнийг анхаарах хэрэгтэй гэсэн саналтай байна. Баярлалаа.

Б.Дэлгэржаргал: за баярлалаа, одоо дээрх танилцуулгуудтай холбоотой асуулт, саналтай гишүүд гарваа өргөөд, оролцоно уу.

Н.Баярсайхан: МУУҮА-ийн санал нь бүх хувийн хэвшлийн байр суурь биш байх, гишүүн байгууллагуудын санал байх. Өмнө нь олон хууль тогтоомжууд байсан одоо ч шинээр хуулиуд гарах байх. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль нь батлагдсан тохиолдолд хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийг сайжруулахад хувь нэмрээ оруулах хууль учраас уул уурхайн ассоциаци дэмжих нь зүйтэй. Мөн олон мэргэжлийн холбоод байгаа, жоншны, нүүрсний, алтны, баяжуулах үйлдвэрийн холбоодууд байгаа, саналаа өгөх байх. Эрдэнэтuya захирлаас асуухад энэ санал нь баталгаажуулалтын тайландаа өгсөн санал уу эсвэл МУУҮА-ийн байр суурь гэж ойлгох уу гэдгийг тайлбарлана уу. Баярлалаа.

Б.Эрдэнэтuya: Бид баталгаажуулалтын тайланг гишүүн байгууллагууд руу явуулсан, ирсэн саналыг нэгтгээд бичгээр ажлын албанд хүргүүлнэ. Манайд 30 гаруй компанийн гишүүнчлэлтэй, хорин таван мянган уурхайчид ажилладаг томоохон байгууллага юм. Өнөөдөр уул уурхайн ассоциацийн байр суурийг илэрхийлсэн гэж ойлгож болно, нөгөө талдаа гишүүн байгууллагууддаа ил тод нээлттэй байлгах санал санаачилгыг гаргаж байна.

Г.Уранцоож: Эрдэнэтuya захирлын хэлсэн хуулийн хэрэгжилтийг хангах гэдэгтэй санал нэг байна. Хуулийн хэрэгжилтийг хангах саналыг иргэд өөрсдөө гаргадаг учраас ил тод нээлттэй байх хууль зайлшгүй хэрэгтэй болоод байна гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярсайханы танилцуулгатай санал нэг байна, манай Хүний эрх хөгжил төв ТАН эвслийн гишүүн байгууллага, биднээс гарсан санал байгаа.

Цолмон зохицуулагчийн танилцуулсан ажлын төлөвлөгөөнд хуулийн агуулгад орох асуудлыг яриад байна. Хуулийн агуулга угаасаа яригдаад байгаа, одоо хуулийн ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа гэж найдаж байгаа. Хуулийг өргөн барих, батлуулахад хуулийн ажлын хэсэг ямар төлөвлөгөөтэй ажиллах вэ гэдэг нь маш чухал байгаа энэ талаар төлөвлөгөө байна уу? Хариуцах гэдэг дээр талууд баймаар зарим нь хэцүү байгаа бол ТАН эсвэл байж болох байх. Энэ нь ажлын

хэсгийн төлөвлөгөөнд орох ёстой гэж бодож байна, энэ тал дээр Цолмон та хариулт өгөх боломж байна уу? Баярлалаа.

Ш.Цолмон: Зөвлөмжид маш олон том, жижиг асуудлууд байгаа, иймээс бид ерөнхийд нь зөвлөмжийг хүлээж аваад гол асуудлаа хэрэгжүүлэх байдлаар хандсан. Хуулийг өргөн барьж байгаа нь Засгийн газар иймд бид хуулийн ажлын хэсэгт орж ажиллах замаар хувь нэмрээ оруулах бололцоотой гэж харж байна. Одоо ХЗДХЯ-нд хуулийн ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байгаа, үүнд ТАН эвсэл оролцох боломжтой. Түүнээс биш зэрэгцээд янз бүрийн юм байгуулаад ажиллах нь хэр зохимжтой гэдгийг сайн мэдэхгүй байна. Баярлалаа.

Г.Уранцоож: Баярлалаа, хамгийн гол нь зэрэгцээд янз бүрийн юм байгуулаад ажиллах нь чухал биш, энэ хуулийн төсөл хоёр парламент дамжаад явж байна. Одоо ХЗДХЯ-нд очоод хичнээн удахыг бид хэлж мэдэхгүй иймээс уг процессыг хурдасгах тал дээр ажлын хэсэг яах ёстой вэ? Ажлын хэсэгт орж байгаа териин байгууллага биш юм гэхэд иргэний нийгмийн байгууллага, магадгүй компаниуд оролцох боломжтой гэж ойлгож байгаа. Хууль зүйн яаманд байгуулах ажлын хэсэгт талуудын төлөөлөл оролцож, хуулийг өргөн барих явцыг хурдасгахын тулд юу хийх вэ дээр төлөвлөгөө баймаар санагдаад байна.

Б.Дэлгэржаргал: Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль боловсруулагдаад бараг бэлэн болсон байгаа, шууд хуулийн төсөл дээрээ хэлэлцээд ажиллах боломжтой. Мэргэжлийн үг хэллэгүүд нилээд өөрчлөгдхөөр байгаа. ХЗДХЯ-ны гүйцэтгэх ажлын хүрээнд ил тод байдлын тухай асуудал байдаг. Хуулийн төслийг илүү бодитой болгох, хурдан явуулах үүднээс тус яамруу шилжүүлсэн. Бид ажлын хэсгийн хүрээнд тодорхой дэмжлэг үзүүлэх талаар төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй байх гэж бодож байна.

Ц.Бээжин: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. МБОИЗ-өөс шаардлагын 4.6-д эрдэс баялагийн салбарын гэрээ тус бүрийг төслийн нэрээр, компанийн нэр, худаладан авагчийн нэрээр мэдээлж байх, борлуулалтын орлогыг орлого төвлөрсөн банкны нэрээр мэдээлэх, орон нутгийн иргэд, яам, олон нийтээс санал авсны үндсэн дээр тусгай зөвшөөрлийг олгох гэсэн гурван саналыг оруулж байна. Гэрээ тус бүрийг төслийн нэрээр, компанийн нэрээр мэдээлэх гэдэг нь дараах учиртай. Компаниудын хамтын ажиллагааны гэрээг ил тод болгох зорилготой гэрээний сайтруу ороод үзэхээр нүд хуурсан, олон нийтэд ойлгомжгүй байдаг. Тухайлбал, компанийн нэрээр хайхаар мэдээлэл нь гарч ирэхгүй заавал төслийн нэрээр гэсэн байдаг. Төслийн нэрийг нь мэдэхгүй хүмүүс харах боломжгүй байна, энэ мэдээлэл ил тод биш байна. Иймд бүх төслийн нэрийг ил тод болгох хэрэгтэй. Мөн худалдан авагч компанийн нэрийг бас ил тод болгох шаардлагатай байна. Хоёр дахь санал нь борлуулалтын орлого Монгол банкны дансанд ордоггүй, гадаад банкинд орсон байдаг. Зарим нь улс төрчид, офшор данс, терроризмыг санхүүжүүлж байна гэж үздэг иймээс орлого орсон дансыг ил тод мэдээлэх хэрэгтэй. Тусгай зөвшөөрлийг олгохоор өмнө танилцуулж, санал аваад дараа нь олгож байх хэрэгтэй байна тэгэхгүй бол маш ил хэл ам, тэмцэл гарч байгааг мэдэж байгаа. Говийн бүсийн чүүлганы зөвлөмж ямар их удаж байна вэ, бид хүлээж байна. Баярлалаа.

Б.Дэлгэржаргал: За баярлалаа, бид таны саналыг дэмжиж байна. Энэ онд бид ОҮИТБС-ын тайлангийн маягтыг шинэчилсэн, цаашид боломжтой бол таны саналыг тусгах болно. Орон нутагт тусгай зөвшөөрөл олгоходоо иргэд, олон нийтээс урьдчилан санал авч олгож байгаа, үүнийг иргэд ойлгохгүй байна. Сумын Засаг дарга зөвшөөрлөө өгчихсөн байгаа иймээс орон нутагтай ойлголцлын талаар бид

ярих ёстай. Ашигт малтмалын тухай хуульд оролцоог тодорхой болгох хэрэгтэй байгаа. Тусгай зөвшөөрөл олгоход энд зөвшөөрөл олгож болно гээд орон нутгийн Засаг дарга бичгээ ирүүлсэн байдаг, тухайн газарт нь очибоор иргэд нь бид өгөөгүй гэдэг. Орон нутгийн иргэдийн төлөөлөл нь тухай нутгийн төр захиргаа нь байдаг. Сумын иргэн тус бүрээс нэг бүрчлэн авах асуудал яриад байгаа энэ нь зарчмын хувьд болохгүй байх. Хүн болгон өөр бодолтой, боловсролы түвшин ялгаатай. Иймээс мэдээллийг өгөх талаар ажиллаж байна.

Д.Эрдэнэчимэг: Баталгаажуулалтын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээнд ИНБ-уудад сургалт хийхээр төлөвлөж байгаа юм байна. Үүнийг тодруулах хэрэгтэй байх. Олон нийтэд мэдээлэл хүргэх асуудлыг сургалтаар хязгаарлаж болохгүй байх. Өөрөөр хэлбэл энэ сургалтыг орон нутгийн иргэний байгууллагуудын сургалт гэж болох юм. Өөрөөр хэлбэл ТАН эвслийн болон МБОИЗ зэрэг байгууллагуудад энэ сургалт хэрэггүй харин эдгээр байгууллагуудаар дамжуулаад орон нутгийн байгууллагын чадавхи бэхжүүлэх сургалт гэж тодотгож өгөх санал байна. Мөн ИНБ-ууд хийж чадахуйц ажлуудыг ажлын алба хийх гээд зүтгэдэг. Тэрний нэг жишээ нь, хэдэн жилийн өмнө ЕСБХБ-ны санхүүжилтээр орон нутгийн харилцааны стратеги боловсруулах том төсөл явсан, нэг компани зөвлөх компаниар хийлгэсэн, өмнө нь ил тод байдлаар ажиллаж байгаагүй, мэдэхгүй байгууллагаар хийлгэсэн. Энэ мэт ажлыг ИНБ-ууд хангалттай хийж чадахаар байсан. Тэрний хүрээнд хийгдсэн ажил, туршилтын төсөл, үр дүн нь харагдахгүй өнгөрчихсөн. ОУИТБС-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн ИНБ-уудын чадавхи дээр суурилаад эдгээр ажлуудыг хийлгэх, энэ асуудлыг төлөвлөгөөнд оруулж өгөхийг хүсье.

Мөн нилээн олон мэдээллийг ил тод болгох замаар Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах журамд нэмэлт өөрчлөлт оруулна гэсэн байна. Үүнийг нэг бүрчлэн нягтлаад үзвэл маягтандaa өөрчлөлт оруулаад шийдэх боломж байна. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, жендерийн мэдээллийг заавал журам батлагдахыг хүлээх шаардлагагүй. Мөн зарим ил тод болсон мэдээллийг журам хүлээхгүйгээр холбоосуудыг тайландаа холбочихвол болно гэж бодож байна. Тухайлбал, байгаль орчны мэдээллийн эрхзүйн актуудыг ил тод болгоно гэж байна энэ нь аль эрт хуулийн сайтад байгаа учраас холбоосуудыг татаж оруулахад болно гэж бодож байна.

Гэрээний ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн байгууллага хамгийн их ачааг үүрч, авч явж байгаа. Гэрээний ил тод байдлын сайтыг байгуулаад ажиллаж байсан одоо үүнийг уул уурхайн яаманд юмуу ажлын албанд хүлээлгэн өгөх шийдвэр гаргасан. Өнгөрсөн оны 9 сард гэрээний ил тод байдлыг хангах журам батлагдсан тухай мэдээллийг яамнаас ирүүлсэн. Одоо энэ сайтыг яам эсвэл ажлын алба цааш нь авч явах цаг нь болсон. Энэ журам нь Хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний нэгдсэн бүртгэлд ороогүй байгаа. Одоо хүртэл хуулийн нэгдсэн санд орж, баталгаажаагүй байна. Уул уурхайн салбарт орон нутгийн гэрээнээс гадна олон гэрээ байдаг бараг 14 төрлийн гэрээ байдаг. Энэ бүх мэдээллийг Нийтийн мэдээллийн тухай хуулиар ил тод болгож чадахгүй байгаа. Тэгэхээр энэ журмаа албан ёсны болгосон тохиолдолд гэрээний вэбсайтыг хүлээлгэж өгмөөр байна. Ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах хэрэгцээ шаардлага байгааг харж байна.

Эрдэнэтуюяа захирлын хэлсэн саналыг нийт уул уурхайн компаниудын байр суурь биш байх гэж бодсон боловч компаниудын санал гэж хэллээ. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль батлагдсанаар хөрөнгө оруулалтыг илүү сайн татах

боловжтой, гишүүн байгууллагуудад ямар нэгэн дарамт шахалт үүсэхгүй. Төрийн байгууллагуудын үүрэг оролцоог сайжруулахын тулд хуулийн төслийн батлуулах шаардлагатай байна. Баярлалаа

Танилцуулга гурав: Монголын ОҮИТБС-ын нэгтгэл тайлангийн эхлэлийн тайлангийн төслийн танилцуулга.

Г.Эрдэнэ: Сайн байцгаанаа уу, энэ өдрийн мэндийг хүргэе. Монголын ОҮИТБС-ын 2021 оны нэгтгэл тайлан боловсруулах ажлыг Эс Ай Си Эй компани болон Гроут финанс аудит хамтран гүйцэтгэхээр болсон. Өнөөдөр эхлэлийн тайланг танилцуулахад бэлэн болсон байна. Эхлэлийн тайлангийн хүрээнд ажлын баг, бүтэцийн талаар өрөнхий мэдээлэл, аж ахуйн нэгжүүдийн материаллаг байдал ба цар хүрээг тодорхойлох урьдчилсан үр дүнг танилцуулна. Мөн ОҮИТБС-ын орлогын бус мэдээлэл буюу 2019 оны олон улсын стандартыг хангах бусад мэдээллүүдтэй хэрхэн ажиллах талаар танилцуулна. Манай хоёр компани нь өмнө нь нэгтгэл тайлан хийж байгаагүй, энэ жил анх удаа гүйцэтгэгчээр шалгараад явж байна. Эс Ай Си Эй компани нь статистикийн судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, 2012 онд байгуулагдсан, 30 гаруй ажилтантай, олон улсын гишүүнчлэлтэй байгууллага юм. Гроут финанс аудит 2013 онд үүсгэн байгуулагдсан, аудитын тусгай зөвшөөрөл авсан. Сүүлийн 5 жил тэргүүлэх 20 аудитын байгууллагын нэгээр шалгарсан туршлагатай компани байгаа. Нэгтгэл тайлан бэлтгэх ажил 6 дугаар сарын 2-ноос эхэлсэн. Гэрээгээ өмнө хийсэн байсан ч маргаан гараад Сангийн яамнаас хянагдаад, шалгагдаж байсан учраас ажил 6 сард эхэлсэн. Бид өнгөрсөн жилүүдийн нэгтгэл тайлангуудтай танилцаж судалсан байгаа. Мөн Засгийн газрын болон аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг аваад анхан шатны боловсруулалтаа хийгээд анхан шатны хянан баталгаажуулах ажлаа эхлээд явж байна. Ажлын цар хүрээгээ тодорхойлж, компаниудын сонголтыг хийсэн байгаа.

Тулган баталгаажуулах ажлыг наадмын дараагаас 9 сарын 15 хүртэл хийнэ. Үүний дараа 10 сарын 15 хүртэл тайлангаа боловсруулаад, 15-25 хооронд хэлэлцүүлэх, тайланг хүлээлгэн өгөх үе шатны ажил хийхээр төлөвлөөд ажиллаж байна. Нэгтгэл тайлангийг багт 11 хүн ажиллана, үүнээс 7 нь санхүү, аудит, НББ-ийн чиглэлээр мэргэшсэн баг бүрэлдхүүн байна, тайлан бэлэн болохоор англи хэл рүү орчуулах ажил хийгдэнэ. Бид өнгөрсөн нэг сарын хугацаанд тайлангийн тухай ойлголтоо нэгтгэх, засгийн газрын болон компаниудаас ирсэн мэдээллийг нэгтгэх, датануудыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. 2022 оны 6 сард зохион байгуулсан Говийн бүсийн ил тод байдлын чуулганд оролцож, ил тод байдалтай холбоотой байгууллагуудын тавьсан илтгэл, санал шүүмжийг сонсож өрөнхийдөө энэ тайланд юу анхаарах ёстой вэ гэдэг ойлголтыг авч ажилласан. Бидэнд компанийн 47, засгийн газрын 50 нийт 97 тайланг ирүүлсэн үүн дээр анхан шатны боловсруулалт хийсэн байна. Өнгөрсөн 2020 оны тайлангаас цар тахалтай холбоотойгоор хураангуй хялбаршуулсан тайлан гаргаж эхэлсэн байна, энэ жил мөн уян хатан тайлан бэлтгэнэ. 2021 оны Засгийн газраас 2024 компанийн тайлан, аж ахуйн нэгж байгууллагаас 2024 тайланг хүлээн авсан үүний анхны зөрүү нь 722 тэрбум төгрөг байна. /танилцуулга, тайланг хавсаргав/

Б.Дэлгэржаргал: За баярлалаа, танилцуулгатай холбоотой асуулт байвал гарaa өргөөд оролцено уу.

Н.Баярсайхан: Нэгтгэл тайланд хамрагдах компанийн тоо 64 болсон байна, энэ ажлыг хийх төсөв багассан уу? Тодорхой компанийн нэрийг өгөөд нэгтгэл

тайланда нэмж оруулж болох уу? Компани гэж ойлгох уу эсвэл 64 төсөл гэж ойлгох уу?

Г.Эрдэнэ: Өнгөрсөн жилээс төсөв буурч, уян хатан тайлан гаргах болсон байна. Үүнээс өмнө төсөв өндөр байсан 200 гаруй компани нэгтгэл тайланда хамрагдаж байсан байна. Энэ жил төсөв 50 сая төгрөг, тендер энэ дүнгээр зарлагдсан бид 42 сая төгрөгөөр оролцсон. Төсөв багасахаар уялдуулаад нэгтгэлд хамрагдах компанийн тоо багасах ёстой гэхдээ зайлшгүй шаардлагатай, олон нийтэд мэдээлэл ил болох шаардлагатай компанийг нэмж оруулж болно, нэмэхдээ үндсэн шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг шалгаж үзэх ёстой. Энэ жил 64 компанийг сонгон авсан, үүний цаана илүү олон төслүүд байгаа.

Ц.Бээжин: 64 компани гэж хэн санал тавьсан бэ? Тусгай зөвшөөрөл эзэмшигч 3027 компани тус бүрээр дүн мэдээгээ нэгтгэх, санхүү болохгүй бол аж ахуйн нэгжүүдээс бага зэргийн хандив, хураамж авдагч юмуу тэгэхгүй бол хардлага төрүүлж байна. 3027 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 64-хенийг сонгосон, энэ компаниуд чинь бараг хамгийн их нээлттэй ил тод компаниуд байгаа. Хамрагдаагүй жижиг компаниуд нь хамгийн их зөрчил, будлиан, ус, ойг хамгийн ихээр сүйтгэсэн компаниуд байж мэднэ. Иймээс бүх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тайланда нэмж оруулах саналтай байна. Наадмын дараа МБОИЗ энэ хүсэлтээ албан шаардлагаар хүргүүлнэ, ингэж нүд хуурсан юм хийж болохгүй. МАК гэхэд 10 тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа, Оюутолгой 5 тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа гэтэл зөвхөн нэг лицензийн талбайн мэдээллүүд тайланда ордог. Тийм учраас лиценз тус бүрийг тайланда оруулах хэрэгтэй байна. 2019 оны тайланда Оюутолгой 3 тусгай зөвшөөрөлтэй нэг алт, хоёр хайрга дайрга гэж оруулсан байсан. Хайрга дайрга гэж байхгүй молибдений лиценз байдаг, Эрдэнээ гуай та үүнийг сайн анхаарч судлах хэрэгтэй. Ийм учраас эрдэс баялагийн мэдээллийг худлаа мэдээлэх, нуун дарагдуулах, алтыг хайрга дайрга гэж гаалийн мэдүүлэг бүрдүүлээд гадагш гаргавал яах уу? Иймээс мэдээ мэдээллийг олон талаас нь нягталж үзэж байх хэрэгтэй. Хүн хүч чинь хүрэхгүй бол МБОИЗ-оос туслалцаа ав, манай байгууллага 21 аймагт салбартай, та нарын мэдэхгүй, мэдээллээ авч чадахгүй байгаа Увс аймгийн Давст суманд байгаа нэг ордын тухай мэдээллийг манайхан мэдэж байдаг. Тийм учраас мэдээллэлтэй ИНБ-тай хамтраад наад ажлаа хийвэл ил тод, олон нийтийн дэмжлэг авах сайн ажил болно. Бүх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллүүдийг нэгтгэл тайланда хамруулах хэрэгтэй, 64 компанийн мэдээллээр битгий хүний нүд хуурсан юм хий. Энэ нь ард түмний өмч болсон байгалийн баялагийн ашиглалт, олборлолт, хайгуул, борлуулалтын үйл явцыг аль болох олон улсын түвшинд, үндэсний хэмжээнд ил тод байлгах, олон улсын санхүүжилттэй, олон улсын дэмжлэгтэй, Монголын төр, яамдуудын оролцсон бүтэцтэй үйл ажиллагаа явж байгаа учраас урьдах дутуу гоомой хийсэн алдаагаа засаад, ил тод байдлаар, жинхэнэ иж бүрнээр нь хүртээмжтэй, нээлттэй байдлаар энэ ажлаа цааш явуулъя. Үүн дээр МБОИЗ 21 аймгийн салбар зөвлөл, 300 гаруй төрийн бус байгууллага, идэвхтэнүүдийн хамтаар боломжит бүх байдлаар хамтран ажиллах боломжтой. Та бүхний ажилд амжилт хүсье.

Г.Эрдэнэ: За баярлалаа, нэгтгэл тайланг хийхдээ Бээжин гуайн саналыг онцгой анхаарч ажиллах болно. Нэгтгэл тайланда 64 аж ахуйн нэгж хамруулах тооцоог манай хоёр байгууллага ярилцаад нийт орлогод эзэлж байгаа хувь, ашигт малтмал нөөц ашигласны төлбөрийн хэдэн хувийг эзэлж байна, хэр их компанийг төлөөлж чадах бол гэдэг үзүүлэлтийг харгалзаж үзээд мөн ажил гүйцэтгэх хугацаа, төсөв санхүүгийн боломж, энэ бүхэндээ баригдаад компанийн тоог тогтоосон. Түүнээс ажлын даалгаварт заавал тэдэн компани байна гэж заагаагүй. Таны саналуудыг анхаарч ажиллах болно.

Т.Мөнхзул: Тайланг харахад төрийн байгууллагын тайлагнасан болон компаниудын тайлангийн дүн хоорондоо нилээд зөрүүтэй харагдаж байна. Үүнийг залруулахын тул компаниуд руу үүнийг тодруулаад, залруулга явуул гэдэг албан тоотыг хүргүүлдэг. Ихэнх нь тайлангаа зөв мэдээлээд явж байхад энэ улсын байгууллагууд өнгөрсөн 15 жилийн алдаанаасаа суралцаад, гаргаж байгаа тоон мэдээллээ үнэн зөвөөр бүрэн аль болох алдаа мадаг багатай гаргахгүй байна вэ? хамгийн наад тал нь татвар, Сангийн яамны мэдээ нь аж ахуйн нэгжээс гаргаж байгаа мэдээнээс их хэмжээний зөрүүтэй байна. АМНАТ гэхэд алтны тушаалт хийх болгонд банк суутгаж аваад татварын байгууллагад тухай бүрд нь шилжүүлдэг, компанид ямар нэгэн анхан шатны баримт үлдэггүй, орж байгаа мөнгөөс хасаад тооцдог. Үүнийг баримтаар нотолно гэхэд тухайн үед их хүндрэлүүд үүсдэг. Ажлын хэсгээс тайлангийн дүгнэлт, зөвлөмжтэй холбоотойгоор төрийн байгууллагуудад дахин алдаа гаргахгүй байх талаар албан тоот, мэдэгдлүүдийг хүргүүлдэг үү? Хүргүүлээд явдаг бол байгууллагууд яагаад хэрэгжүүлэхгүй байна? Харьцангуй мэдээлэл нь цэгцэрсэн байгаа Сангийн яам, татвар гэх мэт газруудаас дурдахад орон нутгийн төрийн байгууллага юу ч байхгүй, юу ч аваагүй гээд явуулдаг гэтэл орон нутгийн компаниуд өчнөөн хандив тусламж өгсөн, олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байдаг. Тэгэхээр төрийн байгууллагууд энэ ажлаа анхаарах хэрэгтэй, тохицуулгын ажилд ихээхэн цаг хугацаа зарцуулдаг үүнийг хийдэг зардал мөнгө өссөөд байна. Иймд ажлын хэсэг болон нэгтгэл тайлан гаргаж байгаа компанийн зүгээс төрийн байгууллагын ирүүлж байгаа мэдээллийн юу нь болохгүй, алдаа гараад байна гэдгийг анхааруулж, цаашид давтахгүй байх албан шаардлагыг хүргүүлж байх саналтай байна.

Г.Эрдэнэ: За баярлалаа, саналыг хүлээж авлаа. Бид эхний байдлаар датагаа цэвэрлээд, алдаатай байж болзошгүй мэдээллийг нягтлаад, эхний байдлаар нэгтгэсэн зөрүү нь өндөр гарсан. Үүний учир шалтгааныг бид олсон, одоо ч олоод явж байгаа, шууд төрийн байгууллагуудын алдаа гэж хэлэх боломжгүй. Харин компаниуд маань тайлангаа бөөн дүнгээр нь ижилхэн шивсэн, энэ асар өндөр зөрүү гарч байна. Бид ийм алдааг завсарлаад явж байгаа боловч тайландаа хамгийн анхны үр дүнг оруулсан байгаа. Ерөнхийдөө алдаа бол аль аль талдаа байгаа, тулган баталгаажуулалтынхаа хүрээнд төрийн байгууллага болон компаниуд руу хандаад явна, таны саналыг хүлээж авлаа.

Б.Дэлгэржаргал: Энэ их зөв санал гарч байна. Өмнө нь ЗГХЭГ-ийн түвшинд байхад тайлан мэдээллийг сайн өгдөг байсан одоо ажлын алба манай яамны харьяанд ирснээс хойш төрийн байгууллагууд, яамдуудын мэдээллээ өгөхгүй, өгч байгаа мэдээлэл дутуу алдаатай байх асуудал гарч байна. Сангийн яам чиг үүргийн яам, манайх хэрэгжүүлэгч яам, бид ажлын албатай нийлээд байнга албан бичиг явуулдаг, албан бичиг явуулаад нэмэргүй байна. Төрийн байгууллагуудын уулзалтыг зохион байгуулах талаар сайдад танилцуулсан, наадмын дараа сайд нартай ярилцая гэсэн. Хууль манай яаман дээр нилээд удсан, одоо яаравчлах шаардлага байна.

Д.Эрдэнэчимэг: Нэгтгэл тайланг уян хатан байдлаар хийнэ гэж хаанаас ямар шийдвэр гарсан бэ? ИНБ эсрэг саналтай байсан. Баталгаажуулалтын тайлангийн хэд хэдэн үзүүлэлтүүд хангалтгүй байсан нь үүнтэй холбоотой байх. Олон улсын газартай хийсэн уулзалтаар энэ асуудлаар нилээн их ороогдож асуугдсан. Яагаад уян хатан тайлан хийх болсон бэ? ОУ газар болохоор бид уян хатан тайлан гаргаж болно гэж зөвлөмж өгсөн, ИНБ зөвшөөрөөгүй байхад яагаад ийм тайлан гаргав гэж асуусан, үүнд хариулт авмаар байна. Өмнө нь жил бүр өндөр орлоготой, их татвар

төлсөн 200 гаруй компанийг нэгтгэл тайланда хамруулдаг байсан үүнд эрсдэлд суурилсан аргаар жижиг компаниудыг сонгодог байсан. Энэ жилийн компаниудийг сонгоход эрсдэлд суурилсан аргаар компани нэмэх үү, яах уу? Хууль бусаар олгогдсон тусгай зөвшөөрлийг илрүүлж, тайланда тусгах талаар стандартын шалгуур үзүүлэлт байдаг. 2021 онд дүйцүүлэх хэлбэрээр буюу тусгай зөвшөөрөл олгох журмаас гадуур нилээн хэдэн зөвшөөрөл олгосон мэдээлэл байгаа. Үүнтэй холбоотой мэдээллийг ТАН эвслээс өгч, тайланда хамруулах хүсэлтэй байгаа.

Б.Дэлгэржаргал: Засгийн газрын шийдвэрийн дагуу 2015 онд нэг удаа дүйцүүлэх аргаар тусгай зөвшөөрөл олгосон байдаг. Тухайн үед хэдэн компани орсон байна тэр компаниудад олгосон байх, түүнээс дахин олгоно гэж байхгүй.

Д.Эрдэнэчимэг: Бидэнд мэдээлэл байгаа учраас шалгуульяа гэж байгаа шалгаад байхгүй бол сайн байна.

Г.Эрдэнэ: Эрсдэлд суурилсан аргаар компанийг нэмж оруулах боломжтой байх гэж бодож байна. Өндөр орлоготой том компаниудын тоо 50 байхаар үлдсэн 14-ийг нь эрсдэлд суурилсан аргаар жижиг компаниудаас сонгох боломжтой юм.

Ш.Цолмон: Нэгтгэл тайлангийн зардал их багасаж байгаа, иймд УУХҮЯ-тай зөвшилцэж, уян хатан байдлаар хийхээр шийдвэрлэсэн. Ажлын төлөвлөгөөнд тусгасан, ажлын даалгаврыг гишүүдэд явуулсан байсан, тодорхой санал ирээгүй. Энэ талаар тайлбарыг ОУНБГ-т хэлсэн байгаа. Бид энэ ажлыг яаж ийж байгаад авч явах ёстой.

Б.Дэлгэржаргал: Ер нь сүүлийн жилүүдэд төсөв хүнд байгаа, хэмнэлтийн горимоор ажиллаж байна. Бид энэ төсвөө авч үлдсэн нь их юм байгаа, манай яаманд томилолтыг зардал ч байхгүй байна. Манай яамны төсөв маш бага, улсын төсвийн хайгуул гэдэг жаахан төсөв байдаг өөр юм байдаггүй. Яаманд хэрэгжиж байсан Зэсийн тесөл, нүүрсний төслийг татан буулгасан. Энэ байгаа төсвөөрөө ажиллана, харин компани маань төсөвт баригдахгүй санаачилгатай ажиллах байх гэж харж байгаа, үүнийг анхаараарай.

Д.Цэрэнханд: Увс аймгийн Давст суманд Гачууртын Чинбат гуай тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд ард иргэдэд ашиглуулаад, 50 хувияа өөрөө ашигладаг. Эдгээр тусгай зөвшөөрлийн төлбөр хаана төлөгддөг вэ, хэрхэн яаж хяналт тавьдаг вэ? Орон нутагт олгож байгаа тусгай зөвшөөрлийг иргэдээс санал авч, засаг дарга олгодог. Иргэд эсэргүүцдэг, хэрвээ засаг дарга зөвшөөрлийг олговол нутгийн иргэдэд ад үзэгдэж, хавчигддаг харин олгохгүй бол дээрээс нь Засаг даргыг огцруулах дарамттай байдаг. Аймгийн Засаг дарга нь сум, багийн Засаг даргыг огцруулах шийдвэр гаргах эрх нь байдаг. Тэгэхээр энэ зохицуулалтыг яаж хийх, гарц гаргалгаа олж өгөөч гэсэн саналтай байна.

Б.Дэлгэржаргал: Тусгай зөвшөөрлийг олгоходо эхлээд орон нутгаас санал авдаг. Засаг дарга зөвшөөрсөн байдаг, компани үйл ажиллагаа явуулах гээд яваад очихоор дарга нь алга болчилоод, иргэд нь бид зөвшөөрөөгүй гэсэн асуудал гардаг. Өмнөх даргын үед гарсан шийдвэрийг хүчингүй болгох зарчим байхгүй. Үнэхээр байгаль орчинд хортой байгаа бол мэргэжлийн хяналт, БОАЖЯ-нд хандаад тусгай зөвшөөрлийг цуцлуулах эрх нь байгаа, манай яаманд тусгай зөвшөөрлийн цуцлах эрх байдаггүй. Ашигт малтмалын газарт тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй болон БО-ны 54,1 заалтын дагуу лиценз цуцлах зөвшөөрөл байдаг, өөр эрх байхгүй.

Энэ бүх процессыгийн орон нутгийн иргэд ойлгомоор байна, иргэдээс санал авахгүйгээр олгосон юм шиг яриад байна.

Д.Цэрэнханд: Орон нутгийн засаг дарга нар тал талаасаа хэцүү байдалтай байна, иймд үүнийг шийдэх ямар боломж байна гэж асуусан. Та ширээний ард суугаад газар дээрээ юу болж байгааг мэдэхгүй байна.

Б.Дэлгэржаргал: Би ширээний ард сууж байгаа нь үнэн гэхдээ, 13 жил уурхайд ажилласан, орон нутагт ямар асуудал тулгардагийг мэднэ. Та зөв ярих хэрэгтэй, манай компаниудад буруу бас байгаа, төслөө танилцуулахгүй шууд орж ирдэг, уг нь эхлээд улс оронд ийм ашигтай, орон нутагт ямар өгөөжтэй талаар иргэдэд танилцуулах хэрэгтэй. Таны саналыг ойлголоо.

Г.Эрдэнэ: “Эргэх тэмүүлэл” компани Засгийн газрын болон компаниас ирүүлсэн тайландаа ирүүлсэн байна. Бидний сонгосон 64 компанийд ороогүй байгаа. 1,3 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна, хэрэгтэй гэж үзвэл эрсдэлтэй компанийн тоонд оруулж болно оо.

Н.Баярсайхан: Сэтгэл дундуур байна, энэ жил 64- хэн компани тайландаа орж байна, улсын төсвөөс 42 сая төгрөгөөр санхүүжүүлж байгаа юм байна. Ажлын албанаас санаачилгатай ажилламаар байна. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкинд хүсэлт тавьж санхүүжилтийг нэмэх, компанийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Хэрвээ ажлын алба чадахгүй гэвэл иргэний нийгмийн зүгээс хүсэлт тавъя. Олон улсын төслөөс багагүй хэмжээний мөнгө авч байж, хамгийн гол ажлаа санхүүжилж чадахгүй болохгүй, улсын төсвийг бид ойлгож байна. Бага ч гэсэн мөнгөө авч үлдэж өнөөдөр энэ ажлыг хийх гэж байгаад Уул уурхайн яаманд талархаж байна. Харин Ажлын алба нэмэлт боломжуудыг хайх хэрэгтэй байна. Ийм бэрхшээл зовлон гараад байгааг Ажлын хэсгийн хурал, Үндэсний зөвлөлийн хурлаар яагаад танилцуулахгүй байна вэ? ИНБ-аас доноруудад дэмжлэг хүсэж албан бичиг өгөх саналтай байна. Энэ тайлан бол олон нийтэд танилцуулах тайлан, 64 компанийн ард олон төслүүд байгаа, болж өгвөл төсөл тус бүрээр тайлан бэлтгэхийг хүсье, ийм боломж байгаа. Тусгай зөвшөөрлийг дүйцүүлэн олгох Засгийн газрын шийдвэр 2018 онд гарсан, үйлчлэл нь дууссан гэж ойлгодог, ингэж ч УУХҮЯ, АМГТГ тайлбарладаг. Гэвч өнөөг хүртэл үргэлжлээд байгаа, нэг хэсгийг буцааж өгсөн, одоо өөр газрууд дахин аваад байна. Иргэний нийгмийн байгууллагаас тодорхой баримттай юмыг ил болгож, тайландаа оруулах саналтай байна. Ажлын хэсгийн хурлын ирц хангалтгүй байна, төрөөс хэдэн хүн байна, компаниас хэдэн хүн байна, ирцийн мэдээлэл авьяа, шийдвэр гаргахад хангалттай ирцтэй байна уу? Тендерийн баримт бичиг дээр болон хянан нэгтгэгчийн ажлын даалгавар дээр санал авсан гэж Цолмон дарга хэлсэн. Манай ТАН эвсэл дээр ирээгүй, мэдээгүй бол учлаарай, одоо санал өгөхөд оройтсон уу? Эхлэлийн семинарын дараа санал өгч болдог уламжлалтай байсан, одоо өгч болохоор бол ТАН эвслээс санал өгье, харгалзаж, хүлээж авах боломжтой юу? Өнөө маргаашгүй саналаа бичгээр хүргүүлэх саналтай байна. Үнэхээр сэтгэл дундуур байна, хэдүүлээ ингэж ухралт хийгээд байж болохгүй ээ.

Б.Дэлгэржаргал: Саналыг ойлголоо, албан бичгээр яаралтай ирүүлээрэй. Ирцийн талаар чатан дээр бичээрэй.

Ц.Бээжин: Өнөөдрийн хурлаас шийдвэр гарах юм байна. Шийдвэрт орох саналаа хэлье. Шийдвэрийн 1 дүгээрт, зөвлөмжийг хэн эцэслэн батлах вэ, нэрийг нь зааж өгөх, ТАН болон МБОИЗ-ыг зөвлөмж эцэслэх хэсгийн бүрэлдхүүнд оруулах

саналтай байна. Байгаль орчны яамны оролцоо дуу хоолой энд маш хэрэгтэй байна, өнөөдөр оролцоогүй байна. Орон нутагт гарч байгаа хэрүүл, зөрчил хамгийн гол нь байгаль орчинтой холбоотой зөрчил байдаг. Иймд БО-ны яам, МБОИЗ-ийг энэ бүтцийн үйл ажиллагаанд заавал татаж оруулах хэрэгтэй байна.

3. Цэлмэг: Бид өнгөрсөн хавар томоохон компаниудын ОҮИТБС-ын тайлангийн татвар хураамжтай холбоотой мэдээллүүдийг шалгаж үзсэн, харьцангуй сайн бөглөдөг асуудал бага байсан, харин байгаль орчинтой холбоотой мэдээллийг бөглөх асуудал муу, бараг 50 хувьд хурэхгүй байсан. Ийм сул дататай үед байгаль орчны талаарх мэдээллийг нэгтгэл тайланд оруулах нь хэр зөв бэ? Нөгөө талаас эдгээр маягтыг бөглүүлэхэд МБОИЗ идэвх санаачилгатай ажиллавал ямар вэ? гэсэн саналтай байна. Баярлалаа.

Б.Дэлгэржаргал: Ажлын хэсгийн хурлаас гарах шийдвэрийн төслийн урьдчилан бэлтгэсэн байгаа, үүн дээр ажлын хэсгийн хурлаас гарсан гишүүдийн саналыг нэмж тусгаад батлах саналтай байна. Эхлэлийн тайланг дэмжиж байна, цаашид гишүүдийн гаргасан саналыг боломжоороо тусгаж ажиллах байх гэж найдаж байна. Энэ талаар бидэнтэй зөвлөж ажиллах байх. МБОИЗ-өөс зарим зардлуудыг шийдэх боломжтой гэж байна, албан бичгээр саналаа өгөөрэй, цаашид ажлын уялдаатай ажиллая. Шийдвэрийн төслийн дэмжиж байгаа нь гарaa өргөнө үү.

Гишүүд ажлын хэсгийн хурлын шийдвэрийг дэмжиж, батлав.

Б.Дэлгэржаргал: Сая Өмнөговь аймагт болсон чуулганаас гарсан зөвлөмжийг Ажлын албанаас танилцуулна.

Ш.Цолмон: Говийн бүсийн чуулганаас гарсан зөвлөмжийг ажлын албаны өөрсдийн зүгээс хийх саналаа оруулаад Өмнөговь аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. Одоогоор арай эцэслээгүй байна. Эцэслэхээр нь тарааж, танилцуулья..

Б.Дэлгэржаргал: Зөвлөмжийн мөрөөр юу хийж байгаа талаар анхаарч ажиллах хэрэгтэй байна. Өнөөдрийн хуралдаанд оролцсон та бүхэндээ, гишүүддээ баярлалаа, ажлын амжилт хүсье. Сайхан наадаарай.

Хуралдаан 12,30 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн
дарга:

Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан:
УУХҮЯ-ны Статистик судалгааны
хэлстийн дарга

Б.Дэлгэржаргал

Тэмдэглэлийн хянасан:
ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

А.Отгонтунгалаг

ОҮИТБС-ын Ажлын албаны
Санхүүгийн ажилтан